

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
Т А Й Л А Н**

**I. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ**

***1. Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт***

УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)”-д тулгуурлан аймгийн ИТХ-ын ээлжит бус 5 дугаар хуралдааны 2009 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 05/01 дүгээр тогтоолоор батлагдсан **“Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)”**-ыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

“Дархан-Уул аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 162 арга хэмжээний хэрэгжилт 2010 оны байдлаар 100.0% буюу 5.00 онооны үзүүлэлттэй байна.

*/Хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2011.01.14-ний өдрийн 2-58 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Материал 59 хуудастай./*

***2. Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт***

“Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний аймгийн Засаг даргын хариуцан биелүүлэхээр тусгагдсан 91 зорилт, 169 хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 2010 оны жилийн эцсийн байдлаар 100.0% буюу 5.00 (4 жилийн байдлаар 57,03 хувь буюу 2,85) онооны үнэлгээтэй байна. */Хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2010.12.30-ний өдрийн 2-1596 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн./*

***3. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт***

Аймгийн хэмжээнд нийт 116 үндэсний хөтөлбөр хэрэгжиж, 2010 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 98.82 хувь буюу 4.94 онооны үнэлгээтэй байна.

Аймгийн Засаг даргын 2010 оны 91 дүгээр захирамжаар байгуулагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа 116 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг газар дээр нь очиж шалган үзэж, хэрэгжилт нь удааширч байгаа болон хэрэгжихгүй байгаа заалтуудын талаар харилцан санал солилцон юун дээр анхаарах, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнгийн **Ерөнхий үнэлгээ 100.7%** буюу **4.92** онооны үнэлгээтэй байна.

## **II. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ**

### **1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт**

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт”-т аймгийн Засаг дарга, ЗДТГазар хэрэгжүүлэхээр тусгагдсан 28 зорилт, 125 арга хэмжээний биелэлт 100,0 хувь буюу 5,00 онооны үнэлгээтэй байна. */Хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2010.12.30-ний өдрийн 2-1595 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн./*

### **2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт**

Аймгийн хэмжээнд “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт” 2010 оны байдлаар 100.0 хувь буюу 5.00 оноо, хэрэгжих хугацааны байдлаар хэрэгжилт 80.0% буюу 4.00 онооны үнэлгээтэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт, Засгийн газрын 155 тогтоолын 221 заалт, Ерөнхий сайдын 1 захирамжийн 1 заалт, Засгийн газрын хуралдааны 37 тэмдэглэлийн 55 заалт, 5 албан даалгаврын 21 заалт, нийт 199 тогтоол

шийдвэрийн 300 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. *Хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2010.12.31-ний өдрийн 2-1606 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн./*

### **3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт**

2010 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан “Батламж”-ийн хэрэгжилт 100.0 хувьтай, 5,00 онооны үнэлгээтэй байна. *Хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2010.12.30-ний өдрийн 2-1596 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн./*

### **4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 бүлэг, 177 зорилтыг хэрэгжүүлэх 299 арга хэмжээний хэрэгжилт 2010 оны жилийн эцсийн байдлаар 100.0% буюу 5.00 /4 жилийн байдлаар 54,50 хувь буюу 2,73/ онооны үнэлгээтэй байгааг аймгийн ИТХ-ын 5 дахь удаагийн сонгуулийн ээлжит IX хуралдаанаараа “Хангалттай” гэж дүгнэсэн. *Хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын даргын 2010.12.30-ний өдрийн 2-1596 дугаар албан бичгээр ЗГХЭГ-ын Хяналт, шалгалт, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн./*

## **III. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ**

### **1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт**

Аймгийн Засаг дарга Тэргүүн шадар сайд /СХЗХ/, Шадар сайд /ХТХ, ОБГ, МХГ/, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /БОАЖГ, УЦУОША/, Хууль зүй дотоод хэргийн сайд /ЦГ/, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд /ТАЗГ, ГХБХБГ/, Боловсрол, соёл, шинжлэн ухааны сайд /БСГ/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд /ХХҮХ/, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн сайд /ХХААЖДҮГ/, Эрүүл мэндийн сайд /ЭМГ/, Батлан хамгаалахын сайд /ЦШ/, Статистикийн хороо /Статистикийн хэлтэс/ зэрэг 10 сайдтай байгуулсан “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”-ний хэрэгжилт 2010 оны жилийн эцсийн байдлаар 98,0% буюу 4,90 онооны үнэлгээтэй байна.

## **2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт**

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагуудаас 2010 оны үйл ажиллагааны үр дүнгээр Улсын хэмжээнд Онцгой байдлын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 3 дугаар байрт шалгарсан амжилт үзүүллээ.

Аймгийн хэмжээд 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 4 сум, 20 агентлагын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний 24 багийн 90 гаруй мэргэжилтэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 1, Тамгын газрын даргын 4, ТЗУХ-ийн даргын 2 албан бичгээр хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар чиглэл, зөвлөмжийг бүх сумын Засаг дарга, агентлагийн дарга нарт өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

ХШҮ-ний тасаг нь аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргын баталсан “ХШҮ-гээ хийх хуваарь”, “Удирдамж”-ийн дагуу 4 сум, 20 агентлагийн дарга нарын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын бодлого, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж байгаатай газар дээр нь очиж танилцан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үр дүнд 25 арга хэмжээ бүхий “Зөвлөмж”-ийг тухайн бүх сум, агентлаг бүрээр боловсруулан хүргүүлж, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, сум, агентлагын дарга нарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, ХШҮ-ний тасаг, сум, агентлагийн дарга, тухайн байгууллагын ХШҮ-ний багийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй 3 байгууллагын төлөөлөгч оролцож, хэлтэс, сум, агентлаг бүрийн 2010 оны үйл ажиллагааны үр дүнг:

### 1. Бодлогын 10 баримт бичиг

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- МУ-ын нийгэм, эдийн засгийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл,
- Аймгийн нийгэм, эдийн засгийг 2010 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт
- Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр
- МУ-ын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан “Батламж”
- Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

- Үндэсний хөтөлбөр,
  - ТАХ-ийн “Үр дүнгийн гэрээ”
  - ТЕЗ-аас бүх шатны Ерөнхий менежерүүдтэй байгуулсан “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”
2. Хурлын ирц, зөвлөлгөөний оролцоо, мэдээ, тайлан хугацаандаа ирүүлсэн байдал, боловсруулалтын чанар, **/Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан, Агентлагын дарга нарын хурал, Удирдах ажилтны зөвлөлгөөн/**
  3. Хэрэглэгчийн үнэлгээ,
  4. Аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт,
  5. Аймгийн Засаг даргын захирамж, Албан даалгавар,
  6. Сарын мэдээ,
  7. “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээ зохион байгуулсан байдал,
  8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгаас боловсруулан гаргасан “Зөвлөмж”
  9. МХГ-ын санхүү, хөдөлмөр нийгмийн хамгааллын хяналтын хэлтсээс ирүүлсэн тухайн байгууллагын 2008-2009 оны санхүүгийн баримтад хийсэн хяналт шалгалтын дүн зэрэг 22 үзүүлэлтийг үндэслэн дүгнэлээ.

Аймгийн ЗДТГ-ын 5 хэлтэс, Цэргийн штаб, 4 сум, 20 агентлагын дарга нарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба аймгийн нэгдсэн дүнгээр 87,7% буюу 4,38 оноотой, үүнээс хэлтсийн дүнгээр 88,6% буюу 4.43 оноо, сумдын дүнгээр 86,0% буюу 4.30 оноо, агентлагийн дүнгээр 88,2% буюу 4.41 оноогоор тус тус дүгнэгдсэн байна.

“Үр дүнгийн гэрээ”, “Бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”-г дүгнэсэн үнэлгээгээр аймгийн хэмжээнд 2009 онд 24 байгууллагын дундаж үнэлгээ 90,3% буюу 4.52 оноогоор үнэлэгдсэн бол 2010 онд 22 байгууллагын дундаж үнэлгээ 99.0% буюу 4.95 оноогоор үнэлэгдэж, нийт 17 байгууллагын үзүүлэлтэд тодорхой ахиц гарсан нь явцын үнэлгээ хийж, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгсөн, хэлтэс, сум, агентлагийн жилийн эцсийн ажлын үр дүнг бодитойгоор үнэлж дүгнэсэн нь Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг нь ерөнхий чиг үүрэг, батлагдсан дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулсны үр дүн болно. /”Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, сумд болон агентлагийн дарга нарын 2010 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”-г хавсаргаав./

#### IV. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

##### 1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас хууль тогтоомжийн хэрэгжилт, “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахын зэрэгцээ аймгийн эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, төсөв, санхүүгийн чадавхи, иргэдийн санал хүсэлт, нийгмийн эрэлт хэрэгцээ болон нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудыг улс эх орны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор 2010 оныг **“Дархан хотын 50 жилийн ойг угтсан бүтээн байгуулалт”**-ын жил болгон зарлаж, **“Өрхийн хөгжлийг дэмжигч”**, **“Дархан - Миний хот”** гэсэн 2 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ, 71 ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлснээр биелэлт 100,0%-тай байна.

##### **Нэгдүгээр зорилтын хүрээнд :**

“Дархан-Уул аймгийн өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 136 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж ажилласнаар 27.1 сая.төгрөгийн өртөг бүхий 40.0 тонн төмс, хүнсний ногооны үрийг 1000 өрхөд олгож, аймгийн хэмжээнд 100 ширхэг хүлэмжийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр ногоочдын бүлэгт олгосноор 400 өрх хүлэмжийн аж ахуй эрхлэх нөхцөл боломж бүрдлээ.

Мөн “Өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, төрөл бүрийн сургалтуудыг явуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж, энэ арга хэмжээнд 70 аж ахуйн нэгж, байгууллага 1980 иргэн хамрагдсан ба үүнд өрхийн тариаланг хөгжүүлэх чиглэлээр 5 удаагийн үнэ төлбөргүй сургалтанд 185 иргэд, ЖДҮ-ийг дэмжих төв, “Бизнес-Инкубатор төв” бизнес эрхлэлтийн чиглэлээр 946 иргэд тус тус хамрагдаж, төсвөөс 27.6 сая төгрөг зарцууллаа.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд 2010 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 71 дүгээр тогтоолоор “Дархан-Уул аймгийн 40-өөс дээш насны ажилгүй болон тэтгэврийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг батлуулж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 31 арга хэмжээг тусгаж, 40-өөс дээш насны ажилгүй болон тэтгэвэрт гарсан иргэдийн хөдөлмөрийг нь дэмжих, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар өрх, гэр бүл таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

Дархан сум, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газрын Агропаркуудыг түшиглэн 40 хүлэмжийг нэгдсэн зохион байгуулалттайгаар суурилуулсан нь нэгдсэн

услалтын систем болон мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгөх, нэгдсэн удирдлагаар хангах боломжийг олгосон нь иргэдийн сэтгэлд нийцсэн ажил боллоо.

Монгол Улсын Ерөнхий сайд С. Батболд манай аймагт ирж ажиллах үеэр хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагаатай танилцаж, сайшаахын хамт 35 хүлэмж нэмж өгөхөөр болсон төдийгүй 150 ортой “Эх, нялхсын төв”, “Спорт цогцолбор” байгуулах ажилд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхээ илэрхийлсэн нь бидэнд ихийг бүтээж хийх урам зориг өглөө. Спорт цогцолборын барилга 2011 оноос эхлэх болно.

Ажлын байрыг шинээр бий болгох, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор “Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас нийт 800 гаруй төслийг хүлээн авч сонгон шалгаруулалтыг хийж, 95 төсөлд 887,1 сая төгрөгийн зээлийг олголоо.

2010 оны 8 дугаар сард **“Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга, уулзалт”**-ыг зохион байгуулж, энэ арга хэмжээнд гадаадын 12 орны зочид төлөөлөгчид, дотоодын 150 орчим бизнес эрхлэгчид оролцлоо. Чуулга уулзалтад оролцогчид “Бүс нутгийн уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал, салбаруудын цаашдын хөгжилд шаардлагатай гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломж, гадаадын хөрөнгө оруулалт хийхэд тулгарч байгаа хүндрэл, тулгамдсан асуудал, хөгжлийн гарц” зэрэг асуудлуудыг хэлэлцсэн ба гадаадын хөрөнгө оруулалтыг татах 31 төслийг боловсруулж тус чуулганд оролцогчидод танилцууллаа.

2010 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 77.1 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 24.6 тэрбум төгрөгөөр буюу 46.8%-иар өссөн дүнтэй байна.

2010 онд Дархан-Уул аймагт жилд 2,0 сая тонн нефть боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах гэрээнд холбогдох талууд гарын үсэг зурсан бөгөөд 2011 оны 04 дүгээр сараас барилга, угсралтын ажил эхлэн 3 жилийн дотор барьж дуусгахаар болсныг мэдэгдэхэд таатай байна. Ингэснээр химийн үйлдвэр хөгжиж тэнд 600 ажлын байр шинээр бий болох юм.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилах, борлуулалтыг дэмжих, нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон ТББ-уудтай хамтран орон нутгийн үзэсгэлэн худалдааг 8 удаа зохион байгуулж, “Намрын ногоон өдрүүд-2010” үзэсгэлэн худалдаанд оролцож, хүнсний ногооны үйлдвэрлэлээр Улсын хэмжээнд Дархан сум, Орхон сум “Шилдэг сум”-аар шалгарсан амжилт үзүүлж, иж бүрэн услалтын системээр шагнууллаа.

“Атрын 3 дахь аян” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд 87 иргэн, ахуйн нэгж, байгууллага 12,6 мянган га-д үр тарианы, 28 аж ахуйн нэгж,

байгууллага 256 га-д, 2450 өрх 1433 га-д төмс хүнсний ногооны үйлдвэрлэл тус тус эрхэлж байгаа нь Аяны өмнөх онтой харьцуулахад тариалсан талбай 10.4 мянган га-аар буюу 3.7 дахин, уриншилсан талбай 9.1 мянган га-аар буюу 3.6 дахин нэмэгдэж, талбай ашиглалт 71.5 хувь буюу 24.4 мянган га талбайг бүрэн эргэлтэнд орууллаа.

Аймгийн хэмжээнд энэ онд 6,8 мянган га талбайгаас 8,6 мянган тн үр тариа, 1876,0 га талбайгаас 20,9 мянган тн төмс, хүнсний ногоо хураан авсан байна. Үүний үр дүнд аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт үр тарианы 76.2 хувь, хүнсний ногооны 167.3 хувь, төмсөөр 2 дахин хангах боломжийг бүрдүүллээ.

### **Хоёрдугаар зорилтын хүрээнд:**

2010 оныг “Дархан хотын 50 жилийн ой угтсан бүтээн байгуулалт”-ын жил болгон зарлаж дэвшүүлсэн зорилтын хүрээнд 4.2 га газарт ногоон байгууламж, усан оргилуур бүхий “Дархан-50” цогцолборын бүтээн байгуулалтад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 68.5 сая төгрөгийн материалын, 76,0 сая төгрөгийн мөнгөн хандив, 8.6 сая төгрөгийн машин, механизмийн дэмжлэг туслалцаа үзүүлж дараахь бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Цогцолборын талбайд 20,3 сая төгрөгөөр 602,5 м бохир усны, 716 м цэвэр усны шугам хоолойн угсралтын ажил,
- 25,2 сая төгрөгөөр 870 м урт бетон багана бүхий хашаа,
- 10,7 сая төгрөгөөр 1260 м<sup>2</sup> талбай бүхий бетон автомашины зогсоол,
- “Төрийн далбаа” баганат цогцолбор,
- Усан оргилуурын бохирын болон цэвэр усны шугам угсралт зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэхийн хамт, явган хүний зам, талбайн ажил хийгдлээ.
- 16 ширхэг нарийн бетонон усан оргилуур, 10935 м<sup>2</sup> талбай бүхий явган хүний замын талбай тавьж, гэр загварын 2 ширхэг усан оргилуурын ажлыг эхлээд байна.

Дархан хот байгуулагдсаны 50 жилийн ойн бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 2 удаа хуралдуулж, “Дархан-50” соёл, урлаг, спортын ажлын арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг баталсан.

Дархан хот байгуулагдсаны 50 жилийн ойд зориулсан “Дархан-50” түүхчилсэн ном, гэрэл зургийн үзэсгэлэн, баримтат кино бүтээх соёл, урлаг, спортын ажлын хэсгүүдийг ажил хийгдэж байна.

“Дархан-50” тохижилт, цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргын хамтарсан “Албан даалгавар” гаргаж, 600 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлээ.

2011 онд тохиох Дархан хотын 50 жилийн ойг угтсан бүтээн байгуулалтын арга хэмжээнд ӨМӨЗО-ны Сайхан дүүргээс 100000 юань буюу 20,0 сая төгрөгийн хандив, туслалцаа үзүүллээ.

2010 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд иргэдийнхээ ая тухтай амьдарч ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Үүнд :

- 223,9 сая төгрөгөөр хотын болон хороолол доторхи 8311,9 м<sup>2</sup> талбайд автозам, засвар шинэчлэлтийн ажил хийлээ.
- Дархан сумын 4 дүгээр багийн төмөр замын орчмын байруудын дунд 3 газарт авто зогсоол хийж, замуудыг шинэчиллээ.
- 22,7 сая төгрөгөөр хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 10 га талбайд 13,0 мянган ширхэг модыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор тарьлаа.
- 920,0 сая төгрөгөөр 57,7 м<sup>2</sup> талбай бүхий орон сууцны байрны дээврийн засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ нь нийт орон сууцны 30%-ийг эзэлж байгаа бөгөөд ирэх онд 1,3 тэрбум төгрөгөөр үргэлжлүүлэн хийх болно.
- 76,2 сая төгрөгөөр Дархан сумын 4 дүгээр багийн орон сууцны хороолол доторх зам, Тосгоны 0.7 км замын гэрэлтүүлгийг шинээр тавилаа.
- 650,0 сая төгрөгөөр Дархан сумын 6, 17 дугаар хорооллын хэрэглээний халуун усыг хаалттай системд шилжүүлэх 38 ширхэг узелийг шинээр суурилууллаа.
- Орхон сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт орших “Богочийн дэв”-ийн 50, Шарын гол сумын Санжит багийн 200, Дархан сумын 15 дугаар багийн 350, нийт 600 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангалаа.
- Дархан сумын 3, 5, 6 дугаар багуудын 600 гаруй айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах агаарын шугамыг шинэчиллээ.
- Дархан сумын 5 дугаар багийн Хөтөлийн гудамжны айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах шугамыг шинээр барихад орон нутгийн төсвөөс 10,0 сая, “Дархан-Сэлэлнгийн Цахилгаан түгээх сүлжээ” ХК-иас 40,0 сая, нийт 50,0 гаруй сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэлээ.
- Хонгор сумын төвийн дулаан хангамжийн гадна шугам сүлжээг шинэчлэх засварын ажлыг “Альянс тех “ ХХК эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 205,0 сая төгрөгөөр хийлээ.

- Шарын гол сумын иргэдийг ундны цэвэр усаар хангах зорилгоор Улсын төсвийн 412,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3,2 км шугамыг шинээр тавьж, усны эрэл хайгуулын ажилд 100,0 сая төгрөг зарцуулаад байна.

- Япон улсын Жайка ОУБ-ын “УСАН ХАНГАМЖИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛТ” / 2009-2011 онд хэрэгжих / төслөөр “Дархан-Ус суваг” ОНӨХК-д 9.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, Дархан сумын 5, 6 дугаар багийн цэвэр усны шугамыг солих, 1, 2 дугаар өргөгч станцын тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлтийн ажлууд хийгдлээ.

- Үер усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Дархан сумын Мангирт хорооны нутаг дэвсгэрт 4,5 км үерийн сувгийн ажлыг шинээр хийж, 832,0 сая төгрөг зарцууллаа.

- Дархан сумын 11 дүгээр багийн 10 дугаар байрны 2, 12 дугаар байрны 1 орцны 3 лифтийг засварлан ашиглалтанд оруулж, орон нутгийн төсвөөс 50,0 сая төгрөг зарцууллаа.

- Тайлант хугацаанд “Нэг байгууллага-Нэг төгөл” болон “Монголоо ногооруулья” аяны хүрээнд аймгийн хэмжээнд 123 аж ахуйн нэгж, байгууллага, 8763 иргэн өөрийн хөрөнгөөр 34499 ш мод бутыг тарьж, 68,0 сая төгрөг зарцууллаа.

- Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор НААҮГ-аас “Миний Монгол” цогцолборт хүрээлэнд нөхөн тарилтаар 8 төрлийн 11720 ш модыг тарьж, 2,2 сая төгрөгөөр 2 га талбайд 17000 ширхэг улиасны үрсэлгээг бэлтгэлээ.

- Аймгийн Газар зохион байгуулалтын 2010 оны төлөвлөгөөний дагуу 849 иргэнд 122.2 га газар шинээр өмчлүүлээ.

- Газар ашиглалтыг сайжруулах, хот төлөвлөлтийг ерөнхий төлөвлөгөөний дагуу явуулах зорилгоор ШТС, машин засварын газар, гражын газар 2009, 2010 онд олгохгүй байх шийдвэр гаргаж зөвшөөрөлгүй баригдсан 29 объектыг албадан буулгаж, нүүлгэн шилжүүлээд байна. Мөн аймгийн Засаг даргын 140 дүгээр захирамжаар 61 аж ахуйн нэгж, байгууллагын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх эрхийг хүчингүй болгож, 277 дугаар захирамжаар зөвшөөрөлгүй баригдсан объектыг буулгах, нийтийн зориулалттай орон сууцанд зөвшөөрөлгүй эвдэх, инженерийн шугам сүлжээг өөрчлөхийг хориглох, 346 дугаар захирамжаар 2011 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэл хугацаагаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх эрхийг шинээр олгохыг зогсоох зэрэг шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

- Аймгийн ИТХ-аас хотын иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн, “Морин хуур” цогцолбор, “Дархан 50” цогцолбор зэрэг

нийтийн эзэмшлийн газруудад барилга байгууламж барих газар олгох, шашин, сүм, хийдийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон шийдвэрийг гаргалаа.

- Улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ амгалан тайван ажиллаж амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Төрийн байгууллагуудын нэгдсэн сүлжээ, “Хяналтын нэгдсэн систем”-ийн ажлыг хийж дуусган, ашиглалтад орууллаа.

- 2010 онд манай аймагт хэрэгжиж байгаа “Тогтвортой амжиргаа - II” төслийн хүрээнд 244,6 сая төгрөгийн 16 төсөл амжилттай хэрэгжиж, 139 иргэн түр ажлын байраар хангагдлаа.

- Мөн Хонгор сум нь “Тогтвортой амжиргаа - II” төслийн хүрээнд “Загвар сум”-аар сонгогдон 96,9 сая төгрөгийн 15 төслийг хэрэгжүүлж байна. Эдгээр төслийн үр дүнд малчид, ногоочид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид бүлгээрээ хоршин ажиллах, малын үүлдэр угсаагаа сайжруулах, мал аж ахуйн болон хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг дахин боловсруулах, цаг үеийн гамшиг ослыг хохирол багатай даван туулах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлууд цогцоороо шийдэгдэж байна.

- 2010 онд Европын холбооны “Малын эрүүл мэнд МАА-н зах зээл” төслөөс Мал эмнэлгийн лабораторийн багаж, тоног төхөөрөмжид 15.0 сая, Хувийн мал эмнэлэг, үржлийн нэгжүүдэд багаж, хэрэгсэлд 25.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

- Дархан сумын хэмжээнд 2000 гаруй золбин нохой устгаж, энэ арга хэмжээнд 10,0 сая төгрөг зарцууллаа.

- Аймгийн хэмжээнд 4 нөхөрлөл, 5 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжин 130 га талбайд ойжуулалтын ажлыг Улсын төсвийн 20,0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд 14,0 сая төгрөг зарцууллаа.

- Хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, тэднийг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулан 2010 онд стандартын шаардлага хангасан талбайн теннисний 2 кортыг ашиглалтад оруулж, энэ ажилд орон нутгийн төсвөөс 16,0 сая, хөл бөмбөгийн талбайг ашиглалтад оруулж, үүнд Улсын төсвөөс 100,0 сая төгрөг зарцууллаа.

**Аймгийн ИТХ-ын ээлжит III хуралдаанаар батлагдсан 6 бүлэг, 117 зорилт, 299 хэрэгжүүлэх арга хэмжээтэй 4 жилд хийж гүйцэтгэх “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт, 2010 оны байдлаар 54,5 %-тай байна.**

### **Боловсролын бодлогын талаар**

Боловсролыг олон улсын жишигт ойртуулах Ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх үйл явц 3 дахь хичээлийн жилдээ амжилттай хэрэгжиж байна.

Сургалтын орчин нөхцлийг сайжруулахад 2009-2010 онуудад улсын болон орон нутгийн төсөв, гадаадын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр нийт 19 сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын их засварын ажилд 1 тэрбум 672,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилт хийгдлээ.

2010 оны элсэлтийн Ерөнхий шалгалтын дүнгээр улсын хэмжээнд 518.3 оноогоор 1 дүгээр байр, 2009-2010 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, үйл ажиллагааныхаа үр дүнгээр аймгийн Боловсрол соёлын газар улсад 1 дүгээр байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Ерөнхий боловсролын “Оюуны Ирээдүй” цогцолбор сургууль “Цахим журнал”, 26 дугаар сургууль математикийн сургалтын хоцрогдол арилгах “Стандарт-А” хөтөлбөр, 4 дүгээр сургууль сурлагын ахицаар үнэлэх үнэлгээний арга, “Од” цогцолбор аймагтаа анхны “Цахим сургууль” болсон зэрэг хөгжлийн шинэ, шинэ ололт амжилтуудыг гаргалаа.

Үүний зэрэгцээ яруу найргийн “Болор цом” 28 дахь удаагийн улсын уралдааныг Дархан-Уул аймагтаа анх удаа зохион байгуулсан нь соёлын салбарт томоохон ололт болсон.

Аймгийн хэмжээнд хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр 19 төрлийн арга хэмжээ зохион байгуулж, энэ арга хэмжээнд 6050 хүүхэд хамрагдаж, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, урлаг, спортын арга хэмжээнд 3.7 сая төгрөг зарцууллаа.

Улсын чанартай уралдаан, тэмцээнд 121 хүүхэд оролцсоноос 69 хүүхэд амжилттай оролцон 22 алт, 4 мөнгө, 5 хүрэл медаль хүртэж, 38 хүүхэд тусгай байр эзэлсэн амжилт үзүүллээ.

2010 онд “Зулзагын гол” хүүхдийн зусланд 514 хүүхдийг амрааж, хөгжлийн бэрхшээлтэй 198 хүүхдүүдэд асран хамгаалагчийн хамт чийрэгжүүлэн сувилах үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн Хүүхдийн зөвлөлийн дарга миний бие “Олон улсын хүүхдийн нэвтрүүлгийн өдөр”-ийг тохиолдуулан “Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөл”-ийн хүүхдүүдийг хүлээн авч биечлэн уулзаж санал, хүсэлтийг хүлээн авч, тэдний өмнө тулгамдаж буй бэрхшээл, шийдвэрлэх асуудлуудын талаар нээлтэй, чөлөөтэй ярилцаж, санал бодлоо солилцлоо.

### **Эрүүл мэндийн бодлогын талаар**

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудад их засвар, тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж хэрэгслээр хангах ажилд Улсын болон орон нутгийн төсөв, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, “Дэлхийн зөн” ОУБ, Тогтвортой амьжиргаа – II төсөл зэрэг байгууллагуудын санхүүжилтээр 780,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Тайлант хугацаанд Амбулаторийн үзлэгт давхардсан тоогоор 85298 иргэн хамрагдаж, 20994 иргэн хэвтэн эмчлүүлж, аймгийн хэмжээнд нийт 170881 ор хоног ашигласан бөгөөд ор хоног ашиглалтын хувь 97,8%-д хүрч, түргэн тусламжийн 24482 дуудлага хүлээн авч, зохих үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд хүүхдийн эндэгдэл 10.0 пормилль болж улсын түвшнээс 2 дахин буурч, сүүлийн 2 жил эхийн эндэгдэлгүй ажиллаж байна.

Аймгийн ЗДТГ, ЭМГ, өрхийн эмнэлгүүдтэй хамтран зуны чийрэгжүүлэх сувиллыг “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж, сувилалд 8-16 дугаар багийн эмзэг бүлгийн өрхийн 338 хүүхдийг хамрууллаа.

Манай аймгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, оношлогоо эмчилгээ хийхэд зориулан БНСУ-ын Католик эмчилгээний холбооноос аймгийн Нэгдсэн эмнэлэгт 80,0 сая төгрөгийн нүдний оношлогоо, мэс заслын иж бүрэн багаж, хэрэгслийг хандивлалаа.

2010 онд улсын чанартай 69 арга хэмжээнд манай аймгийн тамирчид оролцож, 452 багц медаль хүртсэн ба Үндэсний спортын 4 дүгээр их наадамд манай аймгийн баг, тамирчид улсад 3 дугаар байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бие бялдрын түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд нийт хүн амынхаа 15 хувийг 1 сарын хугацаанд хамруулсан үзүүлэлтээрээ Улсад 1 дүгээр байрт шалгарсан амжилт үзүүлж, 30,0 сая төгрөгийн өртөг бүхий чийрэгжүүлэлтийн иж бүрэн төхөөрөмжөөр шагнууллаа.

### **Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогын талаар**

Нийгмийн халамжийн багц хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор эх хүүхэд, халамжийн болон нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмад настны асаргаа, алдарт эхийн 1, 2 дугаар одон, шинэ гэр бүл, шинээр төрсөн

хүүхдэд олгох халамжийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 18655 хүн хамрагдаж 2.657,8 тэрбум, “Хүний хөгжил сан”-гийн хишиг хувиас 94121 иргэнд 9.459 тэрбум төгрөг тус тус олголоо.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд 552 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, 1802 ажлын байр шинээр бий боллоо.

2010 онд нийгмийн даатгалын санд 14.0 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөгөө 107,6 хувиар давуулан биелүүлж, тэтгэврийн даатгалын сангаас өндөр настан, тахир дутуу, тэжээгчээ алдсан нийт 11.0 мянган тэтгэвэр авагчдад 19,5 тэрбум төгрөгийн тэтгэврийг сар бүр тогтмол цаг хугацаанд нь олгож үйлчиллээ.

### **Санхүү, эдийн засгийн бодлогын талаар**

2010 онд Улсын болон орон нутгийн төсвийн орлогод 11160,1 сая төгрөг төвлөрүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 109,8 хувьтай байна. Үүнээс төвлөрсөн төсөвт 3464,9 сая төгрөг оруулж, 101,5 хувь, орон нутгийн төсөвт 7695,2 сая төгрөг оруулж, төлөвлөгөөгөө 114,1 хувиар давуулан биелүүлж, орон нутгийн орлогоос улсын төсөвт 2636,5 сая төгрөг төвлөрүүллээ.

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу 1849 иргэнийг 320,4 сая төгрөгийн татварын хөнгөлөлтөд хамруулсан ба үүнээс хувьдаа орон сууц худалдан авсан 537 иргэнд 199,1 сая, хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлсөн 1312 иргэнд 121,3 сая төгрөгийг тус тус буцаан олголоо.

Автотээврийн техникийн улсын үзлэгт 6730 тээврийн хэрэгсэл хамрагдаж, 227,7 сая төгрөгийг төсөвт орууллаа.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай” хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтын тендер бүрийг нээлттэй шалгаруулах замаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг тэгш оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэн хангаж ажилласнаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3254,1 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 254,4 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 267,5 сая, нийт 3.8 тэрбум төгрөгийн ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

### **Батлан хамгаалах, гамшгаас хамгаалах бодлогын талаар**

2010 оны цэрэг татлагын хяналтын тоог бүрэн биелүүлэхийн хамт цэргийн дүйцүүлэх албанд шинээр 20 иргэнийг бүртгэн авч, одоогоор нийт 52 иргэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байна.

Дайчилгаатай Команд штабын хээрийн сургуулийн бэлтгэлийг хангах ажлыг Зэвсэгт хүчний 120 дугаар ангитай хамтран зохион байгуулж, энэ арга хэмжээнд 52 цэргийн үүрэгтэн, 4 бэлтгэл офицер, 2 нэгж автотехник дайчлагдан оролцож, “Дүүрэн хангалттай” үнэлгээ авлаа.

Аймгийн хэмжээнд Олон улсын гоц халдварт хөл хориот өвчин A/H1N1/ вирусээс хамгаалах үйл ажиллагаатай холбогдох шийдвэрийг тухай бүр шуурхай гаргаж ажилласнаар хүн амын осол эндэгдэл, онцгой бэрхшээлгүйгээр холбогдох арга хэмжээг зохион байгууллаа.

Ард иргэдийг болзошгүй гамшгийн үед хохирол багатай эрсдэлгүй даван гарах чадварыг эзэмшүүлэх зорилгоор Улсын хэмжээний Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага сургуулийг 2010 оны 5 дугаар сард зохион байгуулж, уг үйл ажиллагаанд 38 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, давхардсан тоогоор 80,0 мянга гаруй иргэн хамрагдаж, “Дүүрэн хангалттай” үнэлгээгээр дүгнэгдсэн.

Онцгой байдлын газрын Аврах гал унтраах ангиуд нь тайлангийн хугацаанд гал түймрийн 117, гамшиг ослын 9 дуудлага хүлээн авч, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд учирч болох 341,5 сая төгрөгийн өмч хөрөнгө, 37 барилга байгууламж, 3 хүний амь насыг авран хамгааллаа.

### **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын талаар**

Аймгийн “Эрх зүйн туслалцаа төв”-д өмгөөллийн туслалцаа болон хууль зүйн зөвлөлгөө авахаар 102 иргэн хүсэлт гаргаж, үүнээс эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй, нэн ядуу 54 иргэнд үнэ төлбөргүй өмгөөллийн үйл ажиллагаа явуулж, 44 иргэнд хууль, эрх зүйн зөвлөлгөө өглөө.

2010 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 599 гэмт хэрэг үйлдэгдэн гарсан нь өмнөх оны мөн үеэс 1,4 хувиар, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 213 үйлдэгдэн гарч 15,1 хувиар, хулгайлах гэмт хэрэг 120 үйлдэгдэн гарч 9,0 хувиар, хүчингийн гэмт хэрэг 19, албан тушаалын гэмт хэрэг 1 үйлдэгдэн гарсан нь 80 хувиар, ашиглалтын гэмт хэрэг 11 үйлдэгдэн гарч 8,3 хувиар, булаалтын гэмт хэрэг 4 үйлдэгдэн гарч өмнөх оны мөн үеэс 60 хувиар тус тус буурлаа.

Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд 5378 хүн эрүүлжүүлэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 9,2 хувиар буурсан дүнтэй байна.

Хууль хяналтын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор аймгийн Шүүхүүд болон Прокурорын газрын албан хэрэгцээнд иж бүрэн техник хэрэгсэл олгож, энэ арга хэмжээнд аймгийн Засаг даргын нөөц сангаас 4,8 сая, аймгийн Архивын албанд шинэ техник, тоног төхөөрөмж суурилуулахад 10,7 сая төгрөг тус тус зарцууллаа.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нь гүйцэтгэх хуудасны баримт бичгийн бодит биелэлтийг 46,5 хувь, мөнгөн дүнг 52,2 хувьд тус тус хүргэсэн ба шинээр спорт зааланд засвар үйлчилгээ, байрны дулааны шугамыг шинэчлэн засварлахад нийт 37,0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

2010 оны 9 дүгээр сард болсон Төрийн архивын улсын үзлэгээр Дархан-Уул аймгийн Архив тасгийн үйл ажиллагааг 9 үзүүлэлт, аргачлалын дагуу шалгахад **92.7%** буюу “А”, “**Маш сайн**” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэж, аймгуудын дунд Улсын хэмжээнд 1 дүгээр байр эзэлсэн амжилт үзүүлсэн. Архивыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах талаар анхаарч ажилласан, сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалтын ажил төлөвлөгөөтэй, чанартай, мэргэжлийн түвшинд хийгддэг болсон, архивын хадгалалт, хамгаалалтын нөхцөл сайжирсан (ажлын өрөө тасалгаа хүрэлцээтэй, хадгаламжийн сангийн багтаамж сайтай, нягтруулсан шүүгээгээр хангасан), мэдээллийн технологийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төрийн архивыг орчин үеийн хүчин чадалтай, шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангагдсан зэрэг төрийн архивын үйл ажиллагааг сайжруулахад тодорхой арга хэмжээнүүдийг шат дараалалтай авч хэрэгжүүлсний үр дүн гарсан байна.

### **Бүртгэл, мэдээллийн бодлогын талаар**

Аймгийн хэмжээнд иргэний баримт бичгийн зөрчлийг арилгах зорилгоор “Нэг сарын аян”-ыг зохион байгуулж, 77556 иргэн хамрагдаж, 919 иргэнд торгууль шийтгэврийн хөнгөлөлт үзүүлж, 1365 иргэнд дахин болон шинээр иргэний үнэмлэх олгож, огт баримт бичиггүй 17 иргэнийг баримт бичигжүүлж, 2370 иргэний хаягийн хөдөлгөөний зөрчлийг нь арилгалаа.

Аймгийн хэмжээнд “Иргэний шинэчилсэн бүртгэл”-ийн үйл ажиллагааг эхлүүлж, 2010 оны жилийн эцсийн байдлаар 91358 иргэн хамрагдахаас 82760 иргэн хамрагдаж, бүртгэлийн явц 90,5 хувьтай байна.

### **Төрийн удирдлагын талаар**

Аймаг, орон нутгийн хэмжээнд төрийн үйлчилгээг иргэдэд харилцааны болон мэргэжлийн өндөр түвшинд ил тод, нээлттэй, хөнгөн шуурхай үзүүлж, төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт оролцоог идэвхижүүлэх бодлогыг баримтлан ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 91 зорилт, 169 арга хэмжээний хэрэгжилт 57.03%, 2.85 онооны үзүүлэлттэй байна.

2010 оны 3 дугаар сараас эхлэн иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөвлөлгөө, мэдээлэл өгөх, тэдгээрийн өргөдөл, гомдол, хүсэлтийг

хугацаанд нь чирэгдэлгүй, шуурхай барагдуулах зорилгоор аймаг, сумын **“Иргэдийг хүлээн авах өрөө”**-г шинээр нээн ажиллуулсан нь иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулах, тэдэнд шаардлагатай төрийн үйлчилгээний мэдээллийг өгөх, төр, иргэдийн хамтран ажиллах итгэлцлийг бэхжүүлэхэд тодорхой үр дүнгээ өгсөн ажил боллоо. Тайлант хугацаанд “Иргэдийг хүлээн авах өрөө”-нд 240 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 208 иргэнд биечлэн болон утасаар зөвлөлгөө өгч, үйлчилгээ үзүүллээ.

“Иргэдийг хүлээн авах өрөө”-ний үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнес эрхлэгчдэд төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөртэй хамтран төрөөс үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан “Бизнес ширээ”-ний үйлчилгээг 2010 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс аймгийн ЗДТГ-т нэвтрүүлж, нийт 2,4 сая төгрөгийн санхүүжилттэйгээр сурталчилгаа мэдээллийн ажлыг зохион байгуулж, уг ширээний үйлчилгээнд төрийн болон бизнес хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч нийт 17 байгууллагын 97 үйлчилгээний мэдээллийн хуудсыг хамруулж, иргэдийг нэг цэгээс мэдээллээр ханган ажиллаж байгаа бөгөөд нийт 29 иргэнд энэ чиглэлээр үйлчилгээ үзүүллээ.

Аймгийн хэмжээнд 58577 иргэдийн санал, өргөдөл гомдол хүлээн авч, 58077 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 99,1 %-тай байна.

Аймгийн Засаг дарга 2010 онд 4 сумын иргэдтэй хийх уулзалтыг 10 удаа зохион байгуулж, уг уулзалтад 500 гаруй иргэд хамрагдаж, иргэдээс давхардсан тоогоор төрийн 25 байгууллага, албан тушаалтанд хамаарах асуудлаар 160 гаруй санал, гомдол ирүүлснийг судлан үзэж, тухайн иргэдэд хариуг өгч ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж байх тухай” 2007 оны 97-р зарлиг, Засгийн Газрын “Журам батлах тухай” 2007 оны 190 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, оны эхэнд батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу 2010 онд Дархан, Орхон, Шарын гол, Хонгор сум, аймгийн ЗДТГ, түүний хэлтсүүд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагууд, ЦГ, ШШГА, ШША, ОБГ, УБХ, ХХҮХ, НДХ, ЭМГ, БТСГ, ХТХ, БСГ, Гаалийн алба, Статистикийн хэлтэс, Татварын. Хэлтэс, ГХБХБГ, ТАЗГ, ХХААЖДҮГ, Захирагчийн алба, БОАЖГ, СХЗХ зэрэг 25 байгууллага “Нээлттэй өдөрлөг”-өө зохион байгуулж, давхардсан тоогоор 46 төрлийн арга хэмжээнд 56874 иргэн, 273 төрийн болон ТББ, 342 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, давхардсан тоогоор төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудаар 195 удаа мэдээлэл, сурталчилгаа хийлээ 2720 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт 99,2% -тай байна.

Аймгийн “Е - Дархан” дэд хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагуудын нэгдсэн сүлжээ, мэдээллийн тогтолцоог бий болгох, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ, мэдээ, мэдээллийг ил тод, түргэн шуурхай болгох зорилгоор Мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулж хэвлэл, мэдээлэл, төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн үйл ажиллагааг хариуцан, төрийн 88 байгууллагын 62 объектыг шилэн кабелийн сүлжээнд холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн хэмжээнд иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, нэгжийн шат дамжлагыг цөөлж ажил үйлчилгээг ил тод, хүнд суртал чирэгдэлгүй болгох зорилгоор байгуулагдсан “Нэг цонхны үйлчилгээ”-нд төрийн 8 байгууллагын 136 төрлийн төрийн үйлчилгээнд 110437 иргэн хамрагдлаа.

### **Гадаад харилцааны бодлогын талаар**

Дархан-Уул аймаг нь ОХУ, БНХАУ, БНУУ, ХБНГУ, Дани, АНУ, Канад, БНСУ, ӨМӨЗО зэрэг 9 орны 9 хотуудтай хамтын ажиллагаа, харилцаа холбоог улам гүнзгийрүүлж, гадаад харилцааг эдийн засагжуулах тал дээр онцгой анхааран ажиллаж байна.

Дархан-Уул аймгийн Засаг дарга БНХАУ-ын Жилинь мужид ажлын айлчлал хийж, Дархан-Уул аймаг болон Жилинь мужийн хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай “Хэлэлцээр”, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Тун Ляо хотын хооронд шууд харилцаа тогтоох тухай “Санамж бичиг”, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид БНСУ-д албан ёсны айлчлал хийж, Дархан-Уул аймаг болон БНСУ-ын Пухан хотын хооронд “Найрамдалт харилцааны Санамж бичиг”, ИТХ болон БНСУ-ын Жёонжу хотын “VISION” их сургуулийн хооронд хамтын ажиллагааны “Гэрээ”-нд тус тус гарын үсэг зурлаа. */Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын гадаад харилцааны 2010 оны тайланг хавсаргав./*

### **2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал**

Аймгийн ЗДТГ-ын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2009-2018 он/”-ийн хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

**Нэг. Аймгийн ЗДТГ-н албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний хүрээнд 2010 онд 12 зорилт дэвшүүлж, хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулж ажилласан ба уг арга хэмжээнд 33550.7 мянган төгрөг зарцууллаа.

2010 онд аймгийн ЗДТГ-ын төрийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдлийг зохих хууль тогтоомжийн дагуу олгож, 37 албан хаагчид /унаа бүхий албан тушаалтнуудаас бусад/-ын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд 6.08 сая, ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явж амарсны зардалд 0.70 сая, Төрийн жинхэнэ 2 албан хаагчдад төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрч, тэтгэвэр тогтоолгосон тул 36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний 29.4 сая төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламж, гачигдал, зовлон тохиолдсон Тамгын газрын 8 албан хаагчдын ар гэрт нь 1.17 сая, ТАХ-дын дунд зохион явуулах тэмдэглэлт үйл явдал, аймгийн ЗДТГ-т харъяалагддаг 50 ахмадуудад Олон улсын ахмадуудын баярын өдрөөр хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж олгох болон урлаг, спортын чиглэлээр 10 төрлийн арга хэмжээ зохион байгуулах, Монгол Улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын шагналаар шагнагдсан албан хаагчдын урамшуулал, гэр бүлд шинээр мэндэлсэн хүүхдийн урамшуулал зэрэг арга хэмжээнүүдэд 5.047 сая, нийт 42.397 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

#### **Хоёр. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд :**

Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын 2010 оны “Сургалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх 12 арга хэмжээ төлөвлөж ажилласан ба Төрийн захиргааны магистрын “Улирал”-ын сургалтад 2, менежерийн “Улирал”-ын сургалтад 2, Засгийн газрын захиалгат богино хэмжээний сургалтад 36, нийт 40 албан хаагч хамрагдаж, эдгээр сургалтуудын арга хэмжээний зардалд 4.65 сая төгрөг зарцууллаа. Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан хуваарийн дагуу “Мэдээллийн цаг”-ийг 35 удаа зохион байгуулж, уг арга хэмжээнд Тамгын газрын нийт албан хаагчид бүрэн хамрагдлаа.

2010 онд Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 13 албан тушаалын сул орон тоонд 42 иргэн бүртгүүлснээс 26 иргэн шалгалтад тэнцэн нөөцийн жагсаалтад тус тус бүртгэгдлээ.

Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албан тушаалд шинээр ажилтан элсүүлж авахаар 22 сул ажлын байрыг зарлаж, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг зохион байгуулан, 154 иргэнийг бүртгэн авч шалгаруулалтанд оруулж, тэнцсэн 66 иргэнийг нөөцийн жагсаалтад бүртгэлээ. */Аймгийн ЗДТГ-ын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн 2010 оны хэрэгжилтийг хавсаргаав./*

### **3.Төсөв, санхүүгийн ил тод байдал**

#### **Санхүү, эдийн засгийн бодлого, төсвийн гүйцэтгэлийн талаар**

Орон нутгийн нийт орлого төлөвлөгөөгөөр 6746,0 сая төгрөгөөс 7695,2 сая төгрөгөөр буюу **114.1** хувиар, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 143,7 хувиар тус тус давуулан биелүүллээ.

Улсын төсөвт орон нутгийн төсвийн орлогоос **2636.5** сая төгрөгийг **100** хувь төвлөрүүллээ.

Иргэдэд олгох хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хүүхдийн сургалтийн төлбөр төлсөн **1312** хүнд **201.3** сая төгрөг, хувьдаа орон сууц худалдан авсан **537** хүнд **119,1** сая төгрөг буюу нийт **1849** иргэнд **320,4** сая төгрөгийг тус тус бүрэн олгоод байна.

2010 онд Хязгаарлагдмал хувьцаат компани 155, нөхөрлөл 4, хоршоо 5, салбар 6, төрийн бус байгууллага 13, шашны байгууллага 2 нийт 185 аж ахуйн нэгж, байгууллага шинээр бүртгэгдэж, татварын бааз суурь өргөжиж, татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэмэгдэж байна.

- **Төсвийн хөрөнгийн зарцуулалт, зардал хэмнэх, өр авлагыг бууруулах чиглэлээр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын үр дүн:**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хэмжээнд төсөв, санхүүгийн талаар дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэх, орон нутгийн төсвийн зохистой тэнцвэрийг хангах, зарлагын үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн менежерүүд, нягтлан бодогч нарын хүлээх хариуцлагыг өндөржүүлэх, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг орон нутагтаа дэс дараатай зохион байгуулж хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлэн ажилласнаар орон нутгийн төсвийн гүйцэтгэл төлөвлөгөөгөөр 4109,5 сая төгрөг

зарцуулахаас 4057,8 сая төгрөг зарцуулж, 51,7 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж төсвийн урсал өр төлбөргүй ажиллалаа.

2010 онд Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсвийн байгууллагууд, төрийн сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, хянан баталгаажуулалт, баримтын бүрдэлтийг сайжруулах, улсын болон орон нутгийн төсвийг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй, зарцуулахад хяналт тавьж төсвийн хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг судлаж газар дээр үзэх, холбогдох дээд шатны байгууллагад асуудал тавьж хөнгөн шуурхай шийдвэрлэхэд анхаарч зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч ажиллалаа.

Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан гаргах программын нэмэлт өөрчлөлт, засвар үйлчилгээг зардал хэмнэх зорилгоор орон нутагт зохион байгуулж, ..... байгууллага хамрагдлаа.

*\*Ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийг батлах тухай\** Засгийн газрын 143 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын орлого зардагын гүйцэтгэл, төсвийн төсвийг аймгийн Вэйб сайт, аймгийн Засаг даргын тамгын газрын “Мэдээллийн самбар”-т тогтмол байршуулан, орон нутгийн телевиз, ИТХ-ын Тэргүүлэгчид болон ИТХ-ын Төлөөлөгчид, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд мэдээлэл бэлтгэн хэлэцүүлж, иргэдэд төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн төслийг ил тод, нээлттэй хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллалаа.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, хагас, бүтэн жилийн баланс тайланг аймгийн хэмжээнд 4 сум, 60 төсөвт байгууллагаас хүлээн авч нэгтгэн, жилийн эцсийн баланс тайланг Plastic программаар гаргалаа.

#### **4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал**

##### **А. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах 2010 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2009 оны 09 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолоор батлуулан биелэлтийг нь хангаж ажиллалаа.

Аймагт 2010 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12 нэр төрлийн 2781.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан болно. 2010 онд хийхээр төлөвлөсөн уг ажлууд амжилттай хэрэгжсэн гэж үзэж байна.

БСШУ-ны сайдын багцын хөрөнгө оруулалтаар 6 нэр төрлийн 360.5 сая, ЭМ-ийн сайдын багцын хөрөнгө оруулалтаар 2 нэр төрлийн 110.2 сая, ЗТБХБ-ын сайдын багцын

хөрөнгө оруулалтаар 3 нэр төрлийн 850.0 сая төгрөгийн засварын ажлуудын болон БОАЖСайдын багцын хөрөнгө оруулалтаар 1 нэр төрлийн 06.0 сая төгрөгийн уналагын 2 ш морь худалдан авах ажиллагаа хийгдлээ.

Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1460.0 сая төгрөгийн “Төрийн байгууллагуудын хяналтын нэгдсэн систем /Цагдаагийн хяналтын/”-ийг нийлүүлэх, суурилуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

### **Б. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4 нэр төрлийн 249.9 сая төгрөгийн, замын сангийн хөрөнгө оруулалтаар 267.6 сая төгрөгийн ажил бүрэн хийгдсэн.

1.1 Сангийн Яамнаас зөвшөөрөл авах шаардлагатай ажил үйлчилгээ 1 байсан. Энэ нь “Төрийн байгууллагуудын хяналтын нэгдсэн систем /Цагдаагийн хяналтын/-ийг нийлүүлэх, суурилуулах ажлын худалдан авах ажиллагаа байсан.

1.2 Төлөвлөгөөнд тусгагдаагүйгээр худалдан авах ажил үйлчилгээ хийгдээгүй.

1.3 Төлөвлөгөө биелэгдээгүй болон хагас биелсэн ажил үйлчилгээ байхгүй.

1.4 Ямар нэгэн зөрчил гараагүй.

1.5 Тендертэй холбоотой ямар нэгэн гомдол гараагүй.

### **В. Харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны талаар**

2.1 Аймгийн БСГазар, БОАЖГазар тухайн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны захиалагчийн үүргийг гүйцэтгэсэн.

2.2 Худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар төсөвт байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгсөн.

### **Г. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаархи санал дүгнэлт**

3.1 Дархан-Уул аймгийн 2010 оны улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудад захиалагчаар ажиллаж, худалдан авах ажиллагааг 100 хувь бүрэн хэрэгжсэн гэж үзэж байна.

3.2 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Уушигний тасаг, Сэтгэцийн тасгийн дээврийн засварын ажлын тендер хүчингүй болж тендерийг дахин зарлаж хэрэгжүүлсэн.

3.3 Салбарын сайд нараас тухайн онд хийгдэх худалдан авах ажиллагааны эрхийг оны эхэнд эрт шилжүүлээгүйгээс худалдан авах ажиллагаа оройтох, хэрэгжих боломжгүй болох тохиолдол гарч байна. Шалтгаан нь зарим ажлын төсөв бэлэн биш төсөв хийлгээд тендер зарлах гэсээр байтал хугацаа алдаж оройтдог.

3.4 2010 оны худалдан авах ажиллагаа тус бүр маш олон оролцогчтой байлаа.

*“Дархан-Уул аймгийн 2010 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан”-г хавсаргаав./*

## **V. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ**

### **1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ**

Аймгийн 2010 оны эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт 4.75, нийгмийн үзүүлэлт 5.00, хөгжлийн үзүүлэлт 4.89, ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ 4.88 онооны үнэлгээтэй байна.

### **2.Хэрэглэгчийн үнэлгээ**

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 51, 2008 оны 67-р тогтоол, аймгийн ЗДТГ-ын даргын 2009 оны 11 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжийг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын Тамгын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг дарга түүний Тамгын газраас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллалаа.

2010 онд аймгийн хэмжээнд нийт 58577 иргэний санал, өргөдөл гомдол хүлээн авч, 58077 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг амаар болон бичгээр өгсөн бөгөөд өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 99.1 %-тай байгаа ба тусламж хүссэн амьдралын гачигдалтай 35 иргэнд 2,510 сая төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасны дагуу иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, харилцан ярилцах, санал сэтгэгдлээ хэнээс ч хараат бус чөлөөтэй илэрхийлэх боломж бүхий үйлчлүүлэгч иргэдийн ая тухтай байдлыг хангасан **“Иргэдийг хүлээн авах өрөө”**-г 2010 оны 3-р сараас эхлэн нээн ажиллуулж, энэ хугацаанд **240** иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, **208** иргэнд биечлэн болон утсаар зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүллээ. Иргэдийг хүлээн авах өрөө нь иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, уулзаж, ярилцах нөхцлийг бүрдүүлэхээс гадна төр засгийн бодлого, шийдвэр, орон нутгийн захиргааны байгууллагуудын үйл

ажиллагааг иргэдэд хүргэх, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангахад ач холбогдолтой үр дүнгээ өгсөн ажил боллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж байх тухай” 2007 оны 97-р зарлиг, Засгийн Газрын “Журам батлах тухай” 2007 оны 190 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, оны эхэнд батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу 2010 онд 25 байгууллага “Нээлттэй өдөрлөг”-өө зохион байгуулж, давхардсан тоогоор 46 төрлийн арга хэмжээнд 56874 иргэн, 273 төрийн болон ТББ, 342 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 2720 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт 99,2% -тай байна.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээний хүрээнд төрийн бодлого үйл ажиллагааг иргэдэд хүргэх, мэдээлэл өгөх, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах зорилгоор төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн 8 байгууллагаар 195 удаагийн мэдээлэл, сурталчилгааг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, нэгжийн шат дамжлагыг цөөлж, ажил, үйлчилгээг ил тод, авлигаас ангид, хүнд суртал чирэгдэлгүй болгох зорилгоор Швейцарын хөгжлийн агентлагын “Нэг цонхны үйлчилгээ”, “Тогтвортой амьжиргаа - II” төслийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр нийт 83.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Нэг цонхны үйлчилгээ”-г байгуулж, 8 байгууллагын 136 төрлийн үйлчилгээг хамруулж, давхардсан тоогоор нийт 110437 иргэдэд төрийн үйлчилгээг үзүүллээ.

Засгийн газрын тогтоолын дагуу орон нутгийн төрийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг бий болгох зорилгоор “Мэдээллийн самбар”, аймгийн “Цахим хуудас”, “Электрон самбар”-аар цаг үеийн шуурхай мэдээллийг тогтмол шинэчлэн иргэдэд ойлгомжтойгоор мэдээллийг шуурхай хүргэж хэвшлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, ЗГХЭГ-ын дарга “ ... Иргэдээсээ сэтгэл ханамжийн судалгаа, үнэлээг авч, тэдний санал хүсэлтийг зориуд судалж, дүгнэлт хийж байх нь Хурал, Засаг даргын байнга хийх ажил, үйл ажиллагааныхаа

үндэслэлийг зөв тодорхойлох үндсэн арга замын нэг байх ёстой ..." гэсэн зөвлөмж, үүрэг даалгавар өгсөн билээ.

Хэрэглэгчийн үнэлгээг:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт,
2. Тухайн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа гэсэн 2 чиглэлээр явуулж дүгнэлээ.

**Төрийн байгууллагуудын дотоод аудит хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээний багуудаас зохион байгуулсан хэрэглэгчийн үнэлгээний талаар:**

Монгол Улсын Засгийн Газрын 2006 оны 51, 2008 оны 67-р тогтоол, аймгийн ЗДТГ-ын даргын 2009 оны 11–р тушаал, аймгийн Засаг даргын 2009 оны 54 дүгээр захирамжийг тус тус үндэслэн аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасаг нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг дарга түүний Тамгын газраас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2009 оны 54-р захирамжаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тасгийн 2010 оны жилийн төлөвлөгөө”-нд тус тус заасны дагуу “Хэрэглэгчийн үнэлгээ” хийх ажлыг сумд, агентлагууд улирал бүр зохион байгууллаа.

Үйлчлүүлэгч иргэдээс төрийн албан хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллах чиглэл, зөвлөмжийг сумд, агентлагуудад өгч ажилласнаар 2010 онд нэгдсэн буюу хэсэгчилсэн 32 удаагийн хэрэглэгчийн үнэлгээ авах ажлыг зохион байгуулж, нийт 38531 иргэн хамрагдлаа.

№	Байгууллагын нэр	Судалгаанд оролцсон иргэдийн тоо	Үнэлгээний дундаж хувь
1.	ДАРХАН СУМ	7887	80
2.	ШАРЫН ГОЛ СУМ	139	95
3.	ХОНГОР СУМ	40	83
4.	ОРХОН СУМ	124	78,9
<b>Сумдын дундаж үнэлгээ</b>		<b>8190</b>	<b>84,22</b>

1.	ЗАХИРАГЧИЙН АЛБА	10,000	85
2.	УБХ	82	80
3.	ОБГ	400	99
4.	ЦАГДААГИЙН ГАЗАР	2800	70,4
5.	ШША	97	98
6.	СХЗХ	56	80
7.	МХГ	1500	83,6
8.	ТАЗГ	39	88,05
9.	ХХААЖДҮГ	65	100
10.	НААҮГ	351	91
11.	ГХБХБГ	310	79
12.	БОАЖГ	562	81,76
13.	УЦУОША	150	94
14.	ХХҮХ	200	90
15.	НДХ	323	98,45
16.	ХТХ	3908	98,9
17.	БСГ	5911	99,3
18.	ЭМГ	3386	80,3
19.	БТСГ	92	95
20.	ТАТВАРЫН ХЭЛТЭС	109	95
<b>АГЕНТЛАГУУДЫН ДУНДАЖ ХУВЬ</b>		<b>30341</b>	<b>89,33</b>
<b>НИЙТ ҮНЭЛГЭЭ</b>		<b>38531</b>	<b>86,77</b>

Төрийн байгууллагуудын дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хийсэн хэрэглэгчийн үнэлгээний дундаж дүн “Хангалттай” буюу 86,77 хувь буюу 4.33 онооны үзүүлэлттэй байна.

### **1. Төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагын зүгээс хийсэн “Хэрэглэгчийн судалгаа”-ны дүнгийн талаар**

2010 онд аймгийн ХАҮТанхимаас иргэд, бизнес эрхлэгчдээс дараах судалгааг авч дүгнэлээ.

Энэхүү хэрэглэгчийн судалгаа нь бизнесийн орчныг сайжруулах, орон нутгийн болон төр захиргааны байгууллагын зүгээс бизнесийг дэмжих хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа

зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх зорилтыг агуулсан бөгөөд аймгийн ХАУТанхимын гишүүн, тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нийт 78 байгууллага, бизнес эрхлэгчдийн төлөөлөл уг судалгаанд хамрагдлаа.

Хүнд суртлыг багасгах талаар асуулга судалгаанд оролцогчдын

- 6,5 % нь төрийн байгууллагуудын үйлчилгээг удаан гэж дүгнээд, илүү хурдан шуурхай, цаг хугацаанд нь үйлчлээсэй гэж хүсдэгээ илэрхийлсэн байна

-2,5 % нь албан хаагчдыг үүрэг хариуцлагаа сайн биелүүлэхийн тулд илүү чадварлаг, мэргэжлийн байх ёстой гэж дүгнээд хөдөлмөрийн хөлсийг нь ур чадвар болон хүнд үйлчлэх арга барилаар нь ялгаварлан тогтоох нь зүйтэй гэж дүгнэсэн байна.

1% нь –бусад асуудал /илүү үйлчилгээний байгууллагын хандлагатай байх, аливаа ажил үйлчилгээг авахад бүрдүүлэх бичиг баримтын тоог багасгах, мэдээллийг тодорхой өгөх /

Иймд иргэд бизнес эрхлэгчдийн зүгээс төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар 89,74 хувь нь хангалттай үнэлгээ, 10 гаруй хувь нь мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, хүнд суртлыг багасгах, илүү түргэн шуурхай үйлчлэх, үйлчилгээний байгууллагын хандлагыг төлөвшүүлэх, мэдээллийг тодорхой өгөх гэсэн асуудлаар шүүмжлэлтэй хандсан байна.

#### **Цаашид анхаарах асуудлууд:**

1. Хэрэглэгчийн үнэлгээг сумд агентлаг бүр өөр өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулсан асуулгаар авч дүгнэдэг нь нэгтгэн дүгнэхэд бэрхшээлтэй байдаг. Иймд 2011 онд холбогдох мэргэжилтэн шинжээчдээс санал авсны дагуу Хэрэглэгчийн үнэлгээг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг боловсронгуй болгох, сумд агентлагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор “Хэрэглэгчийн үнэлгээний журам”-ыг батлан мөрдүүлэх,

2. Төрийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллааны талаар хэрэглэгчээс үнэлгээ авах ажлыг бие даан зохион байгуулахаас гадна судалгаа шинжилгээний дагнасан байгууллагуудын дунд тендер зарлан гүйцэтгүүлэх замаар хөндлөнгийн мониторинг хийлгэх ажлыг зохион байгуулах, энэ талаар Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар, Өвөрхангай, Орхон болон бусад аймгуудын холбогдох мэргэжилтэн, шинжээчдээс туршлага судлах шаардлагатай байна.

3. Хэрэглэгчийн үнэлгээ хийх ажилд орон нутгийн төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулах, тэднийг чадавхижуулах, судалгаа шинжилгээ, үнэлгээ хийх талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд хамтран ажиллах саналтай байна.

Санал асуулгын дүнгээр аймгаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны үр дүнг аймгийн иргэд **86.7** хувь буюу **4.33** оноогоор үнэллээ.

*/"Дархан-Уул аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх талаар 2010 онд зохиосон ажлын тайлан"-г аймгийн ЗДТГ-ын даргын 2011.01.04-ны өдрийн 2-08 тоот албан бичиг, "Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулсан арга хэмжээний тайлан"-г 2010.10.31-ны өдрийн 2-1305 тоот албан бичгээр ЗГХЭГ-ийн дарга Ч. Хүрэлбаатар-д хүргүүлсэн. "Нэг цонхны үйлчилгээний үйл ажиллагааны тайлан"-г хавсаргаав../"*

## **V. Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн**

### **1. Аймгийн ЗДТГ-ын ололт амжилтууд, шинээр хийсэн ажлууд, үр дүн**

1. 2010 оныг "Дархан хотын 50 жилийн ой угтсан бүтээн байгуулалт"-ын жил болгон зарлаж дэвшүүлсэн зорилтын хүрээнд 4.2 га газарт ногоон байгууламж, усан оргилуур бүхий **"Дархан-50"** цогцолборын бүтээн байгуулалтад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 68.5 сая төгрөгийн материалын, 76,0 сая төгрөгийн мөнгөн хандив, 8.6 сая төгрөгийн машин, механизмийн дэмжлэг туслалцаа үзүүлж, бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна.
2. Монгол Улсын Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2010 онд улс орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмэр оруулсан ажил, амжилтаар **"Барилга, хот байгуулалтын чиглэлээр орон нутагтаа хамгийн их бүтээн байгуулалт өрнүүлсэн хот"**-ын номинацид шалгарч өргөмжлөл, 20,0 сая төгрөгөөр шагнуулсан амжилт үзүүллээ.
3. Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, сум, агентлагын дарга нарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, ХШҮ-ний тасаг бүрэн бүрэлдэхүүнээрээ, сум, агентлагийн дарга,

- тухайн байгууллагын ХШҮ-ний багийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй 3 байгууллагын төлөөлөгч оролцож, хэлтэс, сум, агентлаг бүрийн 2010 оны үйл ажиллагааг 22 үзүүлэлтээр дүгнэсэн нь цаг үеэ олсон, тэдний итгэлийг хүлээсэн, бодит ажил болсон.
4. “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль”-д заасны дагуу иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх, харилцан ярилцах, санал сэтгэгдлээ хэнээс ч хараат бус чөлөөтэй илэрхийлэх боломж бүхий үйлчлүүлэгч иргэдийн ая тухтай байдлыг хангасан **“Иргэдийг хүлээн авах өрөө”**-г 2010 оны 3-р сараас эхлэн нээн ажиллуулж, энэ хугацаанд **240** иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, **208** иргэнд биечлэн болон утсаар зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүллээ. Иргэдийг хүлээн авах өрөө нь иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, уулзаж, ярилцах нөхцлийг бүрдүүлэхээс гадна төр засгийн бодлого, шийдвэр, орон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангахад ач холбогдолтой үр дүнгээ өгсөн ажил боллоо.
  5. 2010 оны 8 дугаар сард **“Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга, уулзалт”**-ыг аймагтаа зохион байгуулж, энэ арга хэмжээнд гадаадын 12 орны зочид төлөөлөгчид, дотоодын 150 орчим бизнес эрхлэгчид оролцлоо. Чуулга уулзалтад оролцогчид “Бүс нутгийн уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал, салбаруудын цаашдын хөгжилд шаардлагатай гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломж, гадаадын хөрөнгө оруулалт хийхэд тулгарч байгаа хүндрэл, тулгамдсан асуудал, хөгжлийн гарц” зэрэг асуудлуудыг хэлэлцсэн ба гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр 31 төслийг боловсруулж тус чуулганд оролцогчидод танилцууллаа.
  6. 2010 оны 9 дүгээр сард болсон Төрийн архивын улсын үзлэгээр Дархан-Уул аймгийн Архив тасгийн үйл ажиллагааг 9 үзүүлэлт, аргачлалын дагуу шалгахад 92.7% буюу “А”, “Маш сайн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэж, аймгуудын дунд Улсын хэмжээнд 1 дүгээр байр эзэлсэн амжилт үзүүлсэн.
  7. Удирдлагын Ерөнхий хуулиудыг ашиглан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр аймгийн ЗДТГ-ын 2010 оны үйл ажиллагааны “Найдвартай ажиллагааны түвшин”-г тодорхойлох ажлыг хийлээ.

8. Орон нутгийн нийт орлого төлөвлөгөөгөөр 6746,0 сая төгрөгөөс 7695,2 сая төгрөгөөр буюу **114.1** хувиар биелүүллээ.
9. Улсын төсөвт орон нутгийн төсвийн орлогоос **2636.5** сая төгрөгийг **100** хувь төвлөрүүллээ.
10. Хүнсний ногооны үйлдвэрлэлээр Улсын хэмжээнд Дархан сум, Орхон сум “Шилдэг сум”-аар шалгарсан амжилт үзүүлж, иж бүрэн услалтын системээр шагнууллаа.
11. Улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ амгалан тайван ажиллаж амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Төрийн байгууллагуудын нэгдсэн сүлжээ, “Хяналтын нэгдсэн систем”-ийн ажлыг хийж дуусган, ашиглалтад орууллаа.
12. **“Дархан-Уул аймгийн өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”**-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 136 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж ажилласнаар 27.1 сая.төгрөгийн өртөг бүхий 40.0 тонн төмс, хүнсний ногооны үрийг 1000 өрхөд олгож, аймгийн хэмжээнд 100 ширхэг хүлэмжийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр ногоочдын бүлэгт олгосноор 400 өрх хүлэмжийн аж ахуй эрхлэх нөхцөл боломж бүрдлээ.
13. “Өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2010 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 71 дүгээр тогтоолоор **“Дархан-Уул аймгийн 40-өөс дээш насны ажилгүй болон тэтгэврийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”**-ийг батлуулж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 31 арга хэмжээг тусгаж, 40-өөс дээш насны ажилгүй болон тэтгэвэрт гарсан иргэдийн хөдөлмөрийг нь дэмжих, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар өрх, гэр бүл таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

### **ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИНД ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУД:**

1. Осол гамшиг, аюулт үзэгдлийн үед аврах шуурхай ажиллагааг зохион байгуулах зорилгоор “Шуурхай бүлэг-105”-ийг шинээр байгуулах,

2. Тус аймгийн Дархан сумын ЗДТГ-т иргэний бүртгэлийн 2 ажилтны орон тоог шийдвэрлэх (Нийслэлд 10.000 иргэнд 1 бүртгэлийн ажилтан ноогдож байхад, Дархан-Уул аймагт 37.000 мянган иргэнд 1 бүртгэлийн ажилтан ноогдож байна.),
3. 150 хүүхдийн хүчин чадалтай 2 цэцэрлэг, 2 сургуулийг тус тус шинээр барих,
4. Хараа хяналтгүй хүүхдүүдийг нийгэмшүүлэх “**Хүүхдийн байр**” шинээр барих,
5. 2500 хүний суудалтай “**Спортын цогцолбор**”-ыг барих,
6. “**Хөдөлмөрийн бирж**”-ийг байгуулах,
7. Эрүүл мэндийн байгууллагуудад тоног, төхөөрөмжийн шинэчлэл хийх (тоног төхөөрөмжийн 75,0 хувь нь хуучирсан),
8. “Атрын 3 дахь аян”-аар олсон амжилтыг бататган, тогтворжуулахын тулд үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдэд НӨАТ төлөгч биш байх тухай санал, хүсэлтүүдийг гаргаж, УИХ-ын гишүүнээр дамжуулан уламжлаад байгаа тул энэ асуудлаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах,
9. “Дархан” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудал удаашралтай байгаа тул уг паркийн ЖДҮ-ийн хэсгийн дэд бүтцийг барьж байгуулах хөрөнгийг шийдвэрлэх,
10. “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт гаргасан 300 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 3,0 тэрбум төгрөгийн төслөөс 94 төсөлд 971,7 сая төгрөгийн зээл олгосон. Уг сангийн эх үүсвэрийг 2,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай байгаа асуудлыг шийдвэрлэх,

#### **А.Үерийн байгууламжийн талаар**

1. Дархан сумын 6,8,15-р багуудын нутаг дэвсгэр дэх үерийн далан, сувгуудыг шинэчлэн, засварлах

#### **Б.Дэд бүтцийн талаар**

2. “Дархан-Ус” ОНӨҮГазрын хотын доторх цэвэр, бохир ус түгээх шугамын засвар, шинэчлэлийн ажлыг эхлүүлэх
3. Орхон сумын цэвэр, бохир усны байгууламжийг сэргээн засварлах, шинэчлэх,
4. Хонгор сумын төмөр замын хэсгийг ус хангамжийн төвлөрсөн эх үүсвэртэй болгох,
5. Нийтийн зориулалттай орон сууцны инженерийн шугам сүлжээг шинэчлэн засварлах,

6. Дархан хотын 14-р багийн 2,3-р хороололын дулаан, цахилгаан хангамжийг сайжруулах, засварлах,
7. Дархан хотыг ЦЭХ-ээр хангадаг Бурхант, Давхарын 110/6 квт-ын дэд станцыг өргөтгөх.

### **В.Барилга, орон сууцны талаар**

1. Нийтийн зориулалттай орон сууцны 3, 11, 12, 13 дугаар хорооллын дэд бүтцийг байгуулах,
2. “Нутгийн захиргааны ордон”-г шинээр барих.

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:  
ТЗУХ-ИЙН ХШҮ-НИЙ ТАСГИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАСАН:  
ТЗУХ-ИЙН ДАРГА Б. АРЪЯА

ТАНИЛЦСАН:  
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА Т. ГАНБОЛД

ЗӨВШӨӨРСӨН:  
ЗАСАГ ДАРГА Г. ЭРДЭНЭБАТ

Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан  
"Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын  
Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх,  
үр дүнг үнэлэх журам"-ын 3 дугаар хавсралт

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

(2010 оны үйл ажиллагааны үр дүн)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1.	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	100.0	5.00
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /14 жилийн байдлаар, 2010 оны байдлаар/	57.03 <sup>1</sup> 100.0 <sup>2</sup>	2.85 <sup>1</sup> 5.00 <sup>2</sup>
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	98.82	4.94
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>99.61</b>	<b>4.98</b>	
2.	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	100.0	5.00
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт /1хэрэгжих хугацааны байдлаар, 2010 оны байдлаар/	87.60 <sup>1</sup> 100.0 <sup>2</sup>	4.38 <sup>1</sup> 5.00 <sup>2</sup>
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	100.0	5.00
		4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт /14 жилийн байдлаар, 2010 оны байдлаар/	54.50 <sup>1</sup> 100.0 <sup>2</sup>	2.73 <sup>1</sup> 5.00 <sup>2</sup>
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>100.0</b>	<b>5.00</b>	
3.	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	98.00	4.90
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	99.0	4.95
<b>Үнэлгээний дундаж оноо</b>		<b>98.5</b>	<b>4.93</b>	
4.	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	100.0	5.0
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	100.0	5.0
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	100.0	5.0
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	100.0	5.00

<b>Үнэлгээний дундаж оноо</b>			<b>100.0</b>	<b>5.00</b>
5.	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	122.0	4.88
		2. Хэрэглэгчийн үнэлгээ	86.7	4.33
<b>Үнэлгээний дундаж оноо</b>			<b>105.5</b>	<b>4.67</b>
<b>ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ</b>			<b>100.7</b>	<b>4.92</b>

---oOo---

Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан  
"Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын  
Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх,  
үр дүнг үнэлэх журам"-ын 3 дугаар хавсралт

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН  
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ**

(2010 оны дүнгээр)

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайланг он	Өөрчлөлт	Үнэлгээ	
					Хувь	Оноо
0	1	2	3	4	5	6
<b>1.</b>	<b>Эдийн засгийн үзүүлэлт</b>					
1.1	Дотоодын нийт бүтээгдэхүүн (сая.төг)	139552,3				
1.2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (1995 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг)	1279,3				
1.3	Хэрэглээний үнийн өөрчлөлт (хувь)	103.8	103.6	-0.2	-	5.00
1.4	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт (хувь)	103.8	109.8	+6.0	105.8	5.00
1.5	Орон нутгийн төсвийн орлогын өсөлт (хувь)	104.1	114.1	+10.0	103.6	5.00
1.6	Төсвийн нийт зардалд өөрийн орлогын эзлэх хувь	7.9	10.7	+2.8	135.4	5.00
1.7	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл (хувь)	102.0	101.3	+0.7	100.7	5.00
1.8	Орон нутгийн төсвийн урсгал өр, авлага (сая.төг)	-	-	-	100.0	5.00
1.9	Орон нутгийн төсвийн урсгал өр, авлагын өсөлт, бууралт (хувь)	186.2	-	-	100.0	5.00
1.10	Малын тоо (мян.төл)	361.5	249.8	-111.7	63.1	3.16
1.11	Нийт малын тоонд өндөр ашиг шимт үүлдэр, угсаа (мах, сүү, ноос, ноолуурын чиглэлийн)-ны малын эзлэх хувь	15.4	21.7	+6.3	136.4	5.00
1.12	Эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг нэгж (фермер, нөхөрлөл, бүлэг)-ийн тоо	35	55	+20	157.1	5.00
1.13	Хураан авсан үр тариа (мян.тн)	9.64	8.63	-1.01	83.5	4.18
1.14	Хураан авсан төмс (мян.тн)	13.36	9.85	-3.51	73.7	3.68
1.15	Хураан авсан хүнсний ногоо (мян.тн)	7.83	8.11	+0.28	103.6	5.00
1.16	Хураан авсан малын тэжээл болон бусад таримал (мян.тн)	0.142	0.554	+0.412	380.3	5.00
1.17	Тариалангийн талбайд байгуулсан ойн зурвасны хэмжээ (га)	-	-	-	-	-
1.18	Шинээр инженерийн шугам сүлжээнд холбогдсон айл өрхийн тоо	150	500	+350	333.3	5.00
1.19	Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын талбайн хэмжээ (га)	793.1	986.9	+193.8	124.4	5.00
<b>Эдийн засгийн үзүүлэлтийн дундаж оноо</b>					<b>140.0</b>	<b>4.75</b>

2.	<b>Нийгмийн үзүүлэлт</b>					
2.1	<i>Хамран сургалтын хувь:</i> <i>-Сургуулийн өмнөх боловсрол</i> <i>-Бага боловсрол</i> <i>-Суурь боловсрол</i>	73.8 100.0 100.0	65.4 <sup>1</sup> 100.0 100.0	-8.4 - -	100.0 100.0 100.0	5.00 5.00 5.00
2.2	<i>Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хангалтын хувь</i>	100.0	100.0	-	100.0	5.00
2.3	<i>Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалтын хувь</i>	99.8	100.0	+0,2	100.2	5.00
2.4	<i>Нэг компьютерт ногдох хүүхдийн тоо</i>	20	19	+1	105.2	5.00
2.5	<i>Ерөнхий боловсролын түвшин тогтоох шалгалтын онооны дундаж (дунд боловсролын сургуульд)</i>	97.8	99.0	+1.2	101.2	5.00
2.6	<i>Ажилгүйдлийн түвшин</i>	4.69	4.59 <sup>2</sup>	- 0.1	102.1	5.00
2.7	<i>Ядуурлын түвшин</i>	-	-	-	-	-
2.8	<i>Хүн амын дундаж орлого, амьжиргааны баталгаажих доод түвшингийн харьцаа</i>	-	-	-	-	-
2.9	<i>Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент</i>	0.9	3.1	+2.2	-	5.00
2.10	<i>Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь</i>	69.5	70.0	+0.5	100.7	5.00
2.11	<i>Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын барагдуулалт (хувь)</i>	29.1	70.3	+41.2	241.6	5.00
2.12	<i>Эхийн эндэгдлийн түвшин (10000 амьд төрөлтөд)</i>	0	0	-	-	5.00
2.13	<i>Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)</i>	25	20	+5	125.0	5.00
2.14	<i>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)</i>	31	29	+2	106.8	5.00
2.15	<i>Халдварт өвчний гаралт (10000 хүн амд ногдох)</i>	1208	1048	+160	115.3	5.00
2.16	<i>Нэг хүртэлх насны хүүхдийн бүрэн дархлаажуулалтын хамралтын хувь</i>	99.3	98.9	+0.4	100.4	5.00
2.17	<i>Тухайн жилд соёл, урлагийн үйлчилгээг хүртсэн үйлчлүүлэгчдийн тоо</i>	290227	383315	+93.088	132.0	5.00
2.18	<i>Театр, чуулга, соёлын төвд шинээр болон сэргээн тавьсан бүтээлийн тоо (урлагийн төрөл, хэлбэрээр)</i>	5	5	-	100.0	5.00
2.19	<i>Тухайн жилд соёл, урлагийн байгууллагад зарцуулсан хөрөнгө оруулалт (мян.төг)</i>	71906.6	109032.5	+37125.9	151.6	5.00
<b>Нийгмийн үзүүлэлтийн дундаж оноо</b>					<b>117.5</b>	<b>5.00</b>
<b>3.</b>	<b>Хөгжлийн үзүүлэлт</b>					

<sup>1</sup> “Цэцэрлэгийн хүүхдийн хоолгы зардлын дундаж норматив батлах тухай” Засгийн газрын 2009 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 100 төгрөгөөр, 24 цагаар ажилладаг цэцэрлэгт 1600 төгрөгөөр тогтоосон”-ыг үндэслэн олгосноор тооцсон болно.

<sup>2</sup> Ажилгүйдлийн түвшинг тооцоходоо Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүйчүүдийн бүртгэлийг үндэслэж гаргалаа.

3.1	Агаарын чанарын лаборатори болон хяналтын цэгийн тоо	2 лаборатори 2 цэг харуул	2 лаборатори 2 цэг харуул	-	100.0	5.00
3.2	Шинээр байгуулсан хог хаягдлын төвлөрсөн цэг (дахин боловсруулах)-ийн тоо	1	1	-	100.0	5.00
3.3	Ногоон байгууламжийн талбайн өсөлт (га/жил)	36.0	46.7	+10.7	129.7	5.00
3.4	Улсын санд хүлээж авсан ойжуулсан талбайн хэмжээ (га/жил)	327.0	175.0 <sup>3</sup>	-	100.0	5.00
3.5	Уул уурхайн зориулалтаар олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлтийн хувь	24.4	17.4 <sup>4</sup>	-7.0	71.3	3.56
3.6	Шинээр ашиглалтад орсон хатуу хучилттай замын урт (км)	2.23	(7273м <sup>2</sup> 223.0 сая. төг) <sup>5</sup>	-	100.0	5.00
3.7	Шинээр ашиглалтад орсон орон сууц (айлаар)	50	75	+25	150.0	5.00
3.8	Цэвэр, бохир усны төвлөрсөн хангамжид хамрагдсан өрхийн нийт өрхийн тоонд эзлэх хувь	51.5	56.8	+5.3	110.3	5.00
3.9	Нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жин (хувь)	-	-	-	-	-
3.10	Жижиг, дунд үйлдвэрийн тоо	38	45	+7	118.4	5.00
3.11	Жижиг, дунд үйлдвэрт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өсөлтийн хувь	8394.0	9483.6	+1089	112.9	5.00
3.12	Шинээр бий болсон ажлын байрны тоо	1552	1802 <sup>6</sup>	+250	116.1	5.00
3.13	Шинээр байгуулсан болон сэргээн засварласан уст цэг, усан сан, худгийн тоо	-	11	+11	100.0	5.00
3.14	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (хувь)	100.0	100.0 <sup>7</sup>	-	100.0	5.00
<b>Хөгжлийн үзүүлэлтийн дундаж оноо</b>					<b>108.4</b>	<b>4.89</b>
<b>ДУНДАЖ ОНОО</b>					<b>122.0</b>	<b>4.88</b>

Тайлбар: Үнэлгээний хувийг тодорхойлохдоо тайлант оны үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж, хувиар илэрхийлж гаргана. Энэхүү үнэлгээний хувийг 0.05-аар үржүүлж үнэлгээний оноог тодорхойлно.

---oOo---

<sup>3</sup> БОАЖЯ-наас баталж өгсөн хөрөнгийн хэмжээгээр ойжуулалтын ажил хийгддэг ба 2010 онд 175.0 га-д ойжуулалт хийх ажлыг 100% хийж гүйцэтгэсэн.

<sup>4</sup> Ой, усан сан бүхий газар, ашигт малтмалыг хориглох тухай хууль шинээр гарсантай холбогдуулж, уул уурхай, ашигт малтмалын чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг БОАЖЯ-наас батлаагүйн улмаас шалтгаалж энэ чиглэлийн аж ауйн нэгж, байгууллагуудын олборлолт хийсэн газруудын нөхөн сэргээлтийн хэмжээ буурсан байна.

<sup>5</sup> 2010 онд аймгийн хэмжээнд 7273 м<sup>2</sup> асфалтан замын шинэчлэл, зам талбайнөргөтгөл хийж гүйцэтгэсэн ба энэ ажилд орон нутгийн төсвөөс 223.0 сая төгрөг зарцуулсан.

<sup>6</sup> Жижиг дундүйлдвэрлэлийг дэмжих сангийн хүрээнд шинээр 270 байнгын ажлын байр, Хөд өлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 1532 ажлын байр тус тус бий болсон.

<sup>7</sup> 2010 онд Дархан-Уул аймаг нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3.8 тэрбум төгрөгийн ажил хийж гүйцэтгэлээ.